



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогтцэций сумын “Цог-өрнөх” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/23/-НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас:
www.umnugovi@audit.gov.mn
Даланзадгад сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533539 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК
Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН
“ЦОГ-ӨРНӨХ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.АРДТҮМЭН ТАНАА

2022.03.15 № 235

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цогтцэций сумын “Цог-өрнөх” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тус байгууллагын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 470 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосон ба Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 50 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг тус тус шинэчлэн баталсантай холбоотойгоор аймгийн эрчим хүч, бохир, цэвэр усны үнэ тариф шинэчлэгдсэн байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант онд Засгийн газраас “Цог-өрнөх” ОНӨААТҮГ-т дулаан хангамж болон цэвэр, бохир усны үнийн хөнгөлөлт, чөлөөлөлтөөр нийт 304.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 244.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 60.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосноос авлага үүссэн байна.

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

018020426

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	344.0	481.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,375.0	5,143.2
	Нийт хөрөнгийн дүн	5,719.0	5,624.4
	Нийт өр төлбөрийн дүн	2,918.0	2,770.2
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,801.0	2,854.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,719.0	5,624.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	711.5	904.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	676.3	786.7
	Үйл ажиллагааны үр дүн	35.1	53.1
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	35.1	53.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,765.9	2,801.0
	Тайлант оны үр дүн	35.1	53.1
	Эцсийн үлдэгдэл	2,801.0	2,854.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	788.2	814.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	760.2	739.0
	Үйл ажиллагааны ЦМГ	28.0	75.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	28.0	75.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	231.0	259.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	259.0	334.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	672.4	845.7
	Урсгал зардал	672.4	845.7
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	711.5	904.8
	Улсын төсвөөс санхүүжих		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	711.5	904.8

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цогтцэций сумын “Цог-өрнөх” ОНӨААТҮГ-ын зорилго нь сум орон нутгийн хөгжлийн хөшүүрэг болсон цахилгаан эрчим хүч, дулаан хангамжийг үйлдвэрлэх хуваарилах, түгээх, цэвэр бохир ус түгээх, зөөвөрлөх зэргээр хэрэглэгчдийн эрх ашгийг хангах, сумынхаа бүтээн байгуулалт хөгжил дэвшлийг хурдасгахад бодитой хувь нэмэр оруулан найдвартай ажиллах явдал юм.

“Цог-өрнөх” ОНӨААТҮГ нь дараах үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх, борлуулах зохицуулалттайгаар хангах,
- Цахилгаан үйлдвэрлэх, борлуулах зохицуулалттайгаар хангах,
- Цэвэр, бохир ус хангамж ариутгах татуурга ашиглалт үйлчилгээ.
- Гагнуур хийх үйлчилгээ,
- Гадаад дотоод худалдаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай ба өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

“Цог-өрнөх” ОНӨААТҮГ нь Цогтцэций сумын ИТХ-ын 2000 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн дугаар 10 тоот тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан байна.

2021 онд Цэвэр, бохир усны системд хэрэглэгчдийг нэмж холбосон, мөн уул уурхайн кампаниудын бохир соруулж, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж, төлөвлөснөөс орлого илүү нэмэгдэх боломжийг бий болгосон байна.

“Цог-өрнөх” ОНӨААТҮГ-ын захирлын тушаалаар 2021 оны орон тоог 25 байхаар баталсан бөгөөд тайлант хугацаанд 3 орон тоог хэмнэн 22 орон тоогоор ажилласан байна.

МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3-д: “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, 3 орон тоог хэмнэн чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх зардлыг гаргахгүй байх” гэж заасантай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✚ МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;

Дөрөв. Аудитын гол асуудал

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Цогтцэций сумын “Цог-өрнөх” ОНӨААТҮГ нь бизнес төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Цогтцэций сумын Засаг дарга “Цог-өрнөх” ОНӨААТҮГ -ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг баталж, тайлант оны нийт орлогыг 804.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 803.7 сая төгрөгөөр, 0.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан ба тайлант онд төлөвлөгөөнд тодотгол хийгдээгүй байна

Нийт орлогын гүйцэтгэл 904.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 100.7 сая төгрөг буюу 12.5 хувиар давж биелсэн байна.

Тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний өртөг өмнөх оноос 155,9 сая төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 5.7 хувиар буюу 45.7 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант оны нийт ашиг 53.1 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 13.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” зохицуулалттай байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Shilendans.gov.mn цахим хуудсанд 146 мэдээлэл байршуулахаас хагас жилээр 1, бүтэн жилээр 2, нийт 3 мэдээлэл хоцроож, сар бүрийн 1, бүтэн жилийн 1, нийт 2 мэдээлэл мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын зарлага 17.2 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 83.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 32.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 51.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 83.3 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 11.3 сая төгрөгийн түвшнээс 72.0 сая төгрөгөөр их хэдий ч санхүүгийн тайланд нөлөөлөлгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Цог өрнөх ОНӨААТҮГ	6	83.3					2	32.3	4	51.0
	НИЙТ ДҮН	6	83.3					2	32.3	4	51.0